

“МОНГОЛ ШУУДАН” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017.04.26

№ 17102

Улаанбаатар хот

Огноо: 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр

Цаг: 10:00-11:30

Хурал болсон газар: “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн хурлын танхимд

Хурлын дарга: Д.Нарангэрэл /ТУЗ-ийн дарга/

Хурлын нарын бичгийн дарга: Д.Цэцгээ /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 18

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 94,222,195

Хурлын ирц: 94.6%

Хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, түүнд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг батлах тухай;
2. Компанийн 2016 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн Аудитын хорооны дүгнэлтийг батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсөв батлах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн тайланг танилцуулах тухай;

“Монгол шуудан” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2017 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10:00 цагт “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК-ийн 4 давхарын хурлын танхимд боллоо. Хуралд ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл, Стратеги, эрсдлийн удирдлагын хорооны дарга Ч.Ганхуяг, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны дарга Д.Дэлгэрмаа, гишүүн С.Мөнгөнцэцэг, хараат бус гишүүн Б.Амарсанаа болон компанийн удирдлагууд хүрэлцэн ирж оролцлоо.

Хурлын дарга Д.Нарангэрэл: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа хүрэлцэн ирж оролцож байгаа та бүхэнд талархал илрэхийлье.

Тооллогын комиссын дарга М.Мөнх-Эрдэнэ нийт саналын эрхтэй хувьцааны 94.6 хувийг эзэмшигчид хуралд оролцож хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухай ирцийн мэдээллийг өгснөөр хурлын дарга Д.Нарангэрэл хурлын дэгийг баталж хурлыг эхлүүлээ.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 1, 2:

“Монгол шуудан” ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар нийт хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлж, Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан буюу өнгөрсөн оны үйл явцын товчоон, зах зээлийн үнэлгээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц,



санхүүгийн тайлан, шуудангийн хөгжлийн чиг хандлага, сүүлийн үед хийгдэж буй ажлын талаар танилцуулга хийлээ. /Танилцуулгыг хавсаргав./

Компанийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын хорооны дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүн С.Мөнгөнцэцэг танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав./

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга буюу хурлын дарга Д.Нарангэрэл танилцууллаа. /Танилцуулгыг хавсаргав./

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Компанийн 2016 оны үйл ажиллагаа болон санхүүгийн байдалд Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэлэлцэж үзээд “Хангалттай” гэсэн дүгнэлт өгсөн байгаа. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.11, 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг баталж өгнө үү гэж хувьцаа эзэмшигчдээсээ хүсье.

ТУЗ-ийн гишүүн Ч.Ганхуяг: Би Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний хувьд болон жижиг хувьцаа эзэмшигчдийг төлөөлөөд хуралд оролцож байгаагийн хувьд хэдэн санал хэлье. Өнгөрсөн жилийн хугацаанд нилээдгүй их ахиц, дэвшил гарган, Засаглалын хувьд ч бид бие биенээ ойлгож, нэг зорилгын төлөө баг болон ажиллаж байна. Өнгөрсөн оны эхний хагас жилд гарч байсан зөрчлүүд арилсан. Б.Анхбаатар захиралтай удирдлагын баг ажилдаа идэвхийлэн орж, үр дүн нь гарч байна. Бид Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө хэлэлцээд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргасан. Энэ нь маш чухал шийдвэр болсон гэж хувьцаа эзэмшигчийн зүгээс хүлээн авч байгаа. Засгийн газрын зүгээс хувьчлалын асуудлыг энэ онд тавих ёстой. Төсвийн тодотголоор “Монгол шуудан” ХК-ийн хувьчлалын асуудал 2017 онд тусгагдаад явж байгаа. Үүн дээр Засгийн газар тодорхой шийдлүүдийг гаргах байх гэж найдаж байна. Цаашдлаа бид шинэ сайхан бүтээгдэхүүнүүдийг нэвтрүүлээд, улам их мэдээлэлтэй, улам их оролцоотой ажиллах болов уу гэж бодож байна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ – 3, 4:

ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Амарсанаа Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсвийг танилцууллаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл санал хураах хуудсыг танилцууллаа. Мөн дээрх хэлэлцсэн асуудлуудтай холбоотой санал хүсэлт байгаа эсэх талаар асуув.

Хувьцаа эзэмшигч Р.Цэрэнпил: 1-рт: 2017 оны төсөв төлөвлөгөөндөө орлого олохуйц, ашигтай ажиллах ямар үйлчилгээ нэвтрүүлэхээр бодож төлөвлөж байгаа вэ? 2-рт: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсөвт Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хорооны дарга гэж 3 хүн байна. Эдгээр нь ямар асуудал хариуцсан, ямар хүмүүс байдаг вэ?

Гүйцэтгэх захирал Б.Анхбаатар: За баярлалаа. Асуултад хариулья. 2017 оны бизнес төлөвлөгөөг компани Төлөөлөн удирдах зөвлөлөөрөө батлуулсан байгаа. Бид



бүтээгдэхүүн үйлчилгээнийхээ чанарыг дээшлүүлж орлогоо нэмэгдүүлэх, хил дамнасан транзит шуудангийн үйлчилгээний цар хүрээг өргөтгөх чиглэлээр орлогоо нэмэгдүүлж ажиллана гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: Дараагийн асуултад хариулья. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Компанийн дүрмэнд 3 хороотой байна гэж заасан. Үүний дагуу Аудитын, засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын, Стратеги, эрсдлийн удирдлагын 3 хороо ажиллаж байгаа. Эднийг Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн дотроос томилдог. Аудитын хорооны даргаар хараат бус гишүүн Ч.Чинзориг, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар гишүүн Д.Дэлгэрмаа, Стратеги, эрсдлийн удирдлагын хорооны даргаар гишүүн Ч.Ганхуяг ажиллаж байна. Эдгээр маань Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд бөгөөд дотороо зохион байгуулалттай хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлээд ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Р.Цэрэнпил: Та бүхэнд баярлалаа. Цаашдаа үйл ажиллагаа нь улам их өсч, сайн сайхан болохоор ногдол ашиг гурван мянган төгрөгт хүрэх байлгүй дээ гэж бодож байна. Та бүхэндээ ажлын амжилт хүсье.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр санал хураалтын ажиллагаанд орлоо. Санал хураалтын дүн гарч байх хугацаанд 10.50-д цайны завсарлага хийв.

Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул хурлыг 11:10 цагт үргэлжлүүлээ.

Тооллогын комиссын зүгээс санал хураалтын дүн болон Тооллогын комиссын тогтоолыг танилцууллаа.

Хэлэлцэх асуудал-1, 2: Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Санал хураалтын дүн

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
94,222,195	94,222,195	100%	0	0	0	0

Хэлэлцэх асуудал-3: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны зардлын төсөв батлах тухай

Санал хураалтын дүн

Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
94,222,195	94,222,190	100%	5	0.0000	0	0



Хурлын дарга Д.Нарангэрэл: Тооллогын комиссын гишүүдэд баярлалаа. Санал хураалтын дүнг үндэслэж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолыг уншиж танилцуулья.

Хурлын дарга Д.Нарангэрэл Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолыг танилцууллаа. Мөн хуралд идэвхитэй оролцсон хувьцаа эзэмшигчид, тооллогын комисс, хурлыг амжилттай зохион байгуулсан компанийн хурал зохион байгуулах комиссын хамт олон, компанийн удирдлагуудад тадархал илэрхийллээ.

Энэ удаагийн хурал 11:20 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Д.ЦЭЦГЭЭ

